

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ШУДАРГА ЁС, ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГУУЛАХ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2014 ОНЫ ТАЙЛАН**

2014 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр

Дархан

Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газраас Авлигатай тэмцэх, шударга ёс, ил тод байдлыг хангах үйл ажиллагааны 2013 оны төлөвлөгөөнд 15 ажил, 28 хэрэгжүүлэх арга хэмжээг тусган, хэрэгжүүлж ажиллалаа.

2014 оныг **“Төрийн үйлчилгээг сайжруулах, хариуцлага, хяналтыг дээшлүүлж, бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх жил”** болгон зарлаж, энэ ажлын хүрээнд:

1.“Авлига, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, төрийн үйл ажиллагааг иргэдэд ил тод, нээлттэй, ялгамжгүй, шударга, хүртээмжтэй, хүнд сурталгүй, хөнгөн шуурхай хүргэж, ажлын чанарыг эрс сайжруулах чиглэлээр шинэчлэл хийнэ”

2.“Бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, ард иргэдийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулна” гэсэн 2 зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлж ажиллалаа.

**Нэг. Бодлогын бичиг баримт боловсруулах, иргэдийн санал хүсэлтийг тусгах чиглэлээр:**

Тайлант хугацаанд аймгийн Засаг дарга батлагдсан хуваарийн дагуу “Иргэдийг хүлээн авах өрөө” -гөөр болон 89 иргэнтэй уулзан тэдний санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэлээ.

Иргэдээс ирсэн санал хүсэлт нь дараах төрөлтэй байлаа. Үүнд:

- Газар хүссэн 40
- Газрын зөвшөөрөл сунгуулахыг хүссэн 13
- Гэр хүссэн 1
- Бусад асуудлаар 35

Уг өрөө нь иргэдийн ая тухтай байдлыг хангахын зэрэгцээ хэрэгцээтэй мэдээллээ шуурхай олж авах, нээлттэй утас болон саналын хайрцгаар саналаа илэрхийлэх, төрийн захиргааны бусад байгууллагуудтай холбогдох өргөдөл, гомдолыг түргэн шуурхай шийдвэрлэх боломж нөхцлийг бүрдүүлж байгаад иргэд талархалтай байна.

Иргэдэд төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй, шуурхай хүргэх зорилгоор АЗДТГазар нь 2013 оны 10-р сарын 24-ний өдрөөс эхлэн нээлттэй утас болох 70371212 дугаарын утсыг ажиллуулж эхэлсэн бөгөөд тайлант хугацаанд 100 иргэний санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлээд байна.

Аймгийн хэмжээнд 2014 онд нийт 42166 иргэний санал, өргөдөл гомдол хүлээн авч, 41519 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, хариуг амаар болон бичгээр өгсөн байна. Шийдвэрлэх хугацаа болоогүй 647 өргөдөл байгаа бөгөөд өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 98.4 хувь буюу 4.92 онооны үзүүлэлттэй байна.

Мөн аймгийн Засаг даргын Тамгын газар нийт 371 иргэний өргөдлийг хүлээн авч, 316 иргэний өргөдлийг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэж, мэргэжлийн болон харьяалах дээд шатны, сумын ИТХ, ЗДТГ-т 20 өргөдлийг шилжүүлэн, шийдвэрлэх хугацаа болоогүй 55 өргөдөл байна.

Сумдад нийт 24310 иргэний өргөдөл, хүсэлтийг хүлээн авсны 704 иргэн амаар, 23606 иргэн бичгээр ирүүлсэн. Сумдын ЗДТГ нь нийт ирсэн 1719 өргөдлийг аймаг, сумын ИТХурал болон ЗДТГ-т, 15099 өргөдлийг мэргэжлийн болон дээд шатны байгууллагад, 706 өргөдлийг цагдаа, шүүх, арбитрын байгууллагад, шилжүүлэн шийдвэрлэсэн байна. Ажил хүссэн 1326 иргэний өргөдлийг судлан үзэж, 1041 иргэнийг ажилд зуучиллаа. Гэр хүссэн 122 иргэний өргөдлийг хүлээн авч 46 иргэнд гэр олгож, 76 иргэнийг гэргүй иргэдийн бүртгэлд бүртгэж авлаа.

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд дэх агентлагуудад нийт 17485 иргэний өргөдөл, хүсэлтийг хүлээн авч, 17179 өргөдлийг хянан шийдвэрлэсэн байна. Хугацаа болоогүй 306 өргөдөл байна. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд 1693 өргөдлийг аймаг сумын ИТХурал болон ЗДТГ-т, 1764 өргөдлийг мэргэжлийн болон холбогдох дээд шатны байгууллагад шилжүүлэн шийдвэрлэлээ.

Аймаг, сумдын ЗДТГ-т иргэдээс ирүүлсэн өргөдөл хүсэлтийн 19.8 хувь нь газар эзэмших, ашиглах, өмчлөх асуудал, 5.45 хувь нь ажлын байр, 3.13 хувь нь нийгмийн даатгал, 15.9 хувь нь нийгмийн халамж үйлчилгээ, 0.5 хувь нь гэр, орон байр, 0.47 хувь нь буцалтгүй тусламж дэмжлэг, 7.9 хувь нь иргэний бүртгэлийн үйлчилгээ, 0.56 хувь нь байгаль орчны чиглэлээр, 0.64 хувь нь хөдөө аж ахуйн чиглэлээр, 0.15 хувь нь төрийн байгууллага албан тушаалтны ёс зүй, харилцааны соёл, сахилга хариуцлагатай холбоотой асуудлаар, 0.81 хувь нь шагналд тодорхойлуулахаар, 0.35 хувь нь орон сууцны дээврийн болон сантехникийн засвар үйлчилгээ, 0.79 хувь нь ахмадын харъяалал, 0.92 хувь нь зам тээврийн асуудлаар, 0.07 хувь нь байгууллагын үйл ажиллагааг сайжруулах талаар тус тус эзэлж байна.

Амжиргааны баталгаа алдагдаж, амьдралын гачигдалтай байдлаа дурьдан тэтгэмж, тусламж хүссэн болон олон улсын чанартай тэмцээн уралдаанд оролцох, бие даасан тоглолтоо зохион байгуулахад тусламж хүссэн 25 иргэнд 7.828.0 / долоон сая найман зуун хорин найман мянга / -н төгрөгийн буцалтгүй тусламж, дэмжлэг олголоо.

### **Хоёр. Төсвийн ил тод байдлыг хангах чиглэлээр:**

Монгол улсын Засгийн газрын 2010 оны "Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг батлах тухай" 143 дугаар тогтоол, 2012 оны Төсөв, санхүүгийн ил тод байдлын тухай 17 дугаар тогтоолуудын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд иргэдэд тусгай зориулалтын шилжүүлэгийн болон орон нутгийн төсвийн байгууллагын төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, өртөлбөрийг байгууллага бүрээр, зардлын зүйлээр нь дэлгэрэнгүй үзүүлэлтээр, санхүүгийн нэгтгэсэн тайланг хагас бүтэн жилээр, төсвийн төсөл, батлагдсан төсөв, түүний хуваарь, аудитын болон санхүүгийн хяналт шалгалт, сангийн яамны дотоод хяналтын шалгалтын материалуудыг бүрэн эхээр нь мэдээллийн самбар, "darkhan.gov.mn" цахим хуудасанд сар бүр байршуулж, ИТХ-ын Тэргүүлэгч, төлөөлөгчидийн хуралдаанд, Засаг даргын зөвлөлийн хуралд мэдээлэл хийж орон нутгийн телевиз болон сонин, сэтгүүлд хэвлэн гаргалаа.

Мөн мэдээлэл, технологийн дэвшлийг ашиглан 2013, 2014 оны орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийн урсгал зардлын төлөвлөлт, тодотголын төслийг fiscal программаар боловсруулж, аймгийн ИТХ-аар батлуулан Засгийн газрын удирдлага, мэдээллийн системд Засгийн газрын удирдлага мэдээллийн системийн Монгол улсын нэгдсэн төсөвт цахимаар нэвтгүүлсэн нь манай аймагт хэрэгжүүлж буй бас нэгэн шинэлэг ажил амжилттай хэрэгжлээ.

2012-2014 оны төсвийн жилд урсгал зардлын төлөвлөлтийг боловсруулахдаа төсвийн тухай хуулинд заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгон төсвийн хөрөнгийг урсгал зардалд бус хөрөнгө оруулалтанд зарцуулах бодлого баримтлан эдийн засгийн өсөлтийг дэмжиж ажиллаж байна.

2013 оны жилийн эцэс, 2014 оны эхний 8 сарын Тусгай зориулалтын шилжүүлэгийн байгууллагуудын болон ороннутгийн төсвийн гүйцэтгэлийг Иргэдийн Төлөөлөгчдийн ХурлынТэргүүлэгчид, Засаг даргын зөвлөлийн гишүүдэд поверпойнтоор мэдээлэл бэлтгэн хэлэлцүүлээ.

Төсвийн байгууллагуудын төрийнсангаар хийгдсэнөдөртутмын гүйлгээгдолоо хоногоор багцлан ЗДТГ-ын СТСХ-ийн самбарт долоо хоног бүр байршуулж байна.

МУЗГ-ын ил тод байдлыг хангах тухай тогтоолын хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд 102 төсвийн байгууллагын мэдээллийн самбарын үйл ажиллагаанд холбогдох газраар дамжуулан хяналт тавьж байна.

2013 оны ил тод байдлын хэрэгжилтийн тайланг УИХ-ын байнгын хорооны дарга, бие даагчид аймгийн төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нарын уулзалтанд Төсөв, санхүүгийн ил тод байдал, шилэн дансны системийн хэрэгжилтийг хангах чиглэлээр хийсэн ажлын тайланг тавьж монголын үндэсний телевиз болон орон нутгийн телевизээр дамжууллаа.

Төсвийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод байдлыг хангах хүрээнд улсын болон орон нутгийн төсвийн гүйцэтгэлийг аймгийн цахим хуудас, АЗДТГ-ын мэдээллийн самбарт сар бүр байршуулан хүргэж байгаагаас гадна тухай бүрд нь цахим хуудсанд нээлттэй байршуулж байна.

### **Гурав. Мэдээллийн ил тод байдлыг хангуулах чиглэлээр:**

Аймгийн Засаг даргын Тамгын газарт Мэдээлэл технологийн алба байгуулагдаад үйл ажиллагаагаа явуулж байна. Тус аймгаас мэдээллийн ил тод байдлыг хангуулах чиглэлээр дараах ажлуудыг хийэ гүйцэтгээд байна. Үүнд:

1.Орон нутгийн ДИ БИ ЭС, ЛХА, ТВ-12 телевизтэй байгуулсан 2013 оны Дархан-Уул аймгийн телевизийн сүлжээгээр зар сурталчилгаа нэвтрүүлэх тухай гэрээг 2014 оны 5 дугаар сарын эхний долоо хоногт дүгнэж, төлбөрийг шилжүүлэв. Улмаар 2014 оны Дархан-Уул аймгийн телевизийн сүлжээгээр зар сурталчилгаа нэвтрүүлэх тухай гэрээг 3 телевиз / “ДИ БИ ЭС”, “ЛХА”, “ТВ-12”/-тэй гэрээ байгуулж, биелэлтийг ханган ажиллаж байна. “Бурхантын цуурай” радиотой хамтран ажиллах гэрээ байгуулж, биелэлтийг ханган ажиллалаа.

2.Аймгийн удирдах ажилтны зөвлөгөөн /нийт 44 удаа/ болон агентлагийн дарга нарын хуралдаан /нийт 40/, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал /нийт 40 удаа /, хэвлэлийн бага хурал /125/, аймаг орон нутгийн үйл ажиллагаатай холбоотой томоохон арга хэмжээнүүдийн талаар орон нутгийн, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилан тухай бүр мэдээ мэдээллийг e-darkhan.com, darkhan.gov.mn сайт болон аймгийн захиргааны facebook хаягт байршууллаа.

3.Орон нутгийн ЛХА, DBS, NBS,RGB,ТВ-12 телевиз, TV-5,“Өдрийн сонин”, “Монцамэ”, “Сэрүүлэг”, “Найрамдлын Дархан”, “Дархан таймс” “Зууны мэдээ” зэрэг сонинд орон нутгийн үйл амьдралтай холбоотой 1463 мэдээ мэдээллийг мөн тендер, урилга, ажлын байрны захиалгатай холбоотой 150 гаруй мэдээллийг e-darkhan.com сайтад, аймгийн Засаг даргын Тамгын газарfacebook хаягт 857 мэдээ мэдээлэл байршууллаа. Аймгийн албан ёсны вэб сайт болох darkhan.gov.mn сайт 2014 оны 05 дугаар сарын 02-нд ашиглалтанд орж өнгөрсөн хугацаанд нийт 50 мэдээ мэдээлэл байршуулсан байна. Мөн орон нутгийн чанартай мэдээ мэдээллүүдийг дамжуулах чиглэлээр darkhantimes.com, news.mn сайтуудтай хамтарч ажиллаж байна.

4.SBN, ТВ-8, ТВ-9, UBS, NTB, ТВ-5 телевизийн уран бүтээлчид манай аймагт ажиллах үеэр аймаг орон нутагтай холбоотой 59 мэдээ мэдээлэл өгч холбогдох удирдлагуудтай уулзуулан ярилцлага мэдээлэл өглөө.

### **Дөрөв. Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр:**

Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсээс тайлант хугацаанд “Авлигын мөн чанар, шалтгаан, хор хөнөөл”, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”, “ХАСХОМ гаргах”, “Авлигатай тэмцэх газрын Мэдүүлгийн бүрдүүлэлтийн програмд хэрхэн ажиллах тухай” зэрэг сэдвүүдээр аймгийн ЗДТГ, Хөдөлмөрийн хэлтэс, Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба зэрэг байгууллагуудын нийт 157 албан хаагчдад сургалт зохион байгууллаа.

Мөн аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний танхимтай хамтран Авлигатай тэмцэхэд иргэн таны оролцоо сэдэвт хэлэлцүүлгийг 50 гаруй иргэдийн төлөөллийг оролцуулан зохион байгууллаа.

Авлигатай тэмцэх газар, Дархан-Уул аймгийн Хэвлэлийн хүрээлэнтэй хамтран Азийн сан төрийн бус байгууллагын санхүүжилтээр хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргахад анхаарах асуудал сэдвээр төрийн албан хаагчид болон эрх бүхий албан тушаалтан 50 хүнд 4 цагийн сургалтыг зохион байгууллаа.

Авлигатай тэмцэх газар, Монгол улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас санаачлан зохион байгуулсан “Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга зам сэдэвт онлайн уулзалтад Дархан-Уул аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга, түүний орлогч, Тамгын газрын дарга, төрийн бусад байгууллагуудын нийт 35 удирдах албан тушаалтан, 17 эрх бүхий албан тушаалтнууд оролцлоо. Уулзалтанд оролцогчдод 4 төрлийн бэлтгэсэн 120 ширхэг сургалтын тараах материалыг олшруулан тарааж ажиллалаа.

Аймгийн ЗДТГ, Дархан, Орхон, Хонгор, Шарын гол сумын ЗДТГ, Байгаль орчны газар, Боловсролын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Захирагчийн алба, Стандартчлал хэмжил зүйн хэлтэс, Тээвэр авто замын газар, Худалдан авах ажиллагааны алба, Үйлдвэр хөдөө аж ахуйн газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс, Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, бусад төсөвт байгууллагуудын ХАСХОМ гаргах нэрсийн жагсаалтыг гарган, хуулийн хугацаанд гаргуулан авах, бүртгэл хөтлөх, Авлигатай тэмцэх газрын мэдүүлгийн бүрдүүлэлтийн програмд шивж оруулах баталгаажуулах ажилд хяналт тавин дээрхи 15 байгууллагын 250 ажилтан, албан хаагчдын ХАСХОМ-г хуулийн хугацаан гаргуулан авлаа.

2014 онд шинээр ажил албан тушаалд томилогдсон 10, их хэмжээний өөрчлөлт орсон 11 албан тушаалтанд ХАСХОМ хэрхэн гаргах, мэдүүлгийн бүрдүүлэлтийн програмд хэрхэн шивж оруулах талаар зөвлөгөө өгч, ХАСХОМ-ыг хүлээн авч цахимд шивүүлж баталгаажууллаа.

2014 оны 01 дүгээр сарын аймгийн ИТХ-ын ажлын албатай хамтран салбарын 18, 2014 оны 06 дугаар сард Хэвлэлийн хүрээлэн ТББ, Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн ажилтнуудтай хамтран салбарын байгууллагуудын 14 эрх бүхий албан тушаалтнуудын сургалтыг тус тус зохион байгууллаа. Мөн салбарын эрх бүхий албан тушаалтнаар шинээр томилогдсон 3 хүнд эрх үүрэг, мэдүүлгийн бүрдүүлэлтийн програмд хэрхэн ажиллах талаар зааж, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, эрх бүхий албан тушаалтны 2 төрлийн нийт 6 ш гарын авлага олгож ажиллалаа.

АЗДТГ-ын Авлигатай тэмцэх шударга ёс ил тод байдлыг хангуулах, арга хэмжээний төлөвлөгөөг гарган ний төслийг боловсруулан Авлигатай тэмцэх газар болон аймгийн ЗДТГ-ын хэлтэс, штабаас саналыг авч тусган аймгийн ЗДТГ-ын даргаар батлуулж ажиллалаа.

Авлигатай тэмцэх, шударга ёс, ил тод байдлын хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган аймгийн ЗДТГ-ын нийт албан хаагчдад танилцуулж гарын үсэг зурууллаа.

Аймгийн e-darkhan.com сайтыг шинэчлэх сайжруулах ажлын хэсгийн хуралдаанд 3 удаа оролцож тус сайтад нэмж тусгуулах цэс, мэдээллийн талаарх саналаа гарган өгч, сайтын эх загварын талаарх саналаа гарган тусгууллаа.

Албан хаагчдын давхар ажил эрхлэлтийн судалгаа, хамаарал бүхий этгээдийн судалгааг гаргуулан авч нэгтгэн гаргалаа.

Согтууруулах ундааны хяналтын тухай хуулийн болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найрууллагын төслийг Хууль зүйн яамнаас ирүүлсэний дагуу аймгийн Иргэний танхимтай хамтран Дархан сумын багийн болон Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтнууд, аймгийн Цагдаагийн газар, Сум дундын 7 дугаар шүүх, аймгийн Прокурорын газар, шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба зэрэг хуулийн байгууллагуудын болон иргэдийн төлөөлөл нийт 110 хүнийг оролцуулсан 2 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Хэлэлцүүлгийн үеэр гарсан саналуудыг нэгтгэн, хурлын тэмдэглэлийн хамт Хууль зүйн яаманд хүргүүлээ.


Мөн Мансуурах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх хөтөлбөр, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны хөтөлбөрийн төслийг хүлээн авч холбогдох хуулийн байгууллагуудаас саналыг нь гаргуулан авч нэгтгэн Хууль зүйн яаманд хүргүүлээ.

#### Тав. Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангуулах чиглэлээр:

Аймгийн 2014 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 99 бараа, ажил үйлчилгээ тусгагдсанаас санхүүжилтийн эх үүсвэрээр нь авч үзвэл 65 хувийг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар, 22 хувь нь орон нутгийн төсвөөс, 13 хувь нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тус тус хийгдэхээр туссан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжигдсэн 1.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 12 ажил, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 8.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 20 бараа, ажил, ОНХС хөрөнгө оруулалтаар 8.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 58 бараа, ажил, үйлчилгээ, бусад захиалагч байгууллагуудаас 0.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий бараа, ажил, үйлчилгээний нийт 19.1 тэрбум төгрөгийн худалдан авалтыг зохион байгууллаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 1.4 тэрбум төгрөгийн 12 худалдан авалт яамдуудаас эрх шилжигдэн ирсэн.



- 2014 оны нийт худалдан авалтын 20 хувь буюу 19 бараа, 1 ажлыг цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулсан.
- 2015 оны бүх худалдан авалтын 50 хувь цахимаар зохион байгуулахаар зорилт тавин ажиллахаар төлөвлөж байгаа.

Үнэлгээний хороонд ажиллах эрх олгох А-3 сертификат олгох сургалт 2 удаа зохион байгуулж 210 хүн хамрагдсан ба одоогоор эрх бүхий 82 хүнтэй ажиллаж байна.

2014 онд 100 гаруй Үнэлгээний хороонд давхардсан тоогоор Төрийн болон ТББ төлөөлөл, ИТХ-ын төлөөлөгчид, иргэдийн 500 гаруй хүн ажилласан.

ХЯНАСАН:

ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Л.АЛТАНЧИМЭГ

БОЛОВСРУУЛСАН:

ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Г.ЭНХСАЙХАН